

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/018/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 384
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн төсвөөс 982,812.5 мянган төгрөгийн дэмжлэг авч, 934,993.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,905,368.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 372,808.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 125,267.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 122,585.5 мянган төгрөгийг зарцуулж, 2,682.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитаар Ерөнхий боловсролын сургуулийн батлагдсан төсвөөс 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Хүүхдийн цэцэрлэгт илүү олгосон, сумын төсвийн эх үүсвэрт урьд оны үлдэгдэл 141,323.3 мянган төгрөгийг төлөвлөж батлаагүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232520384

Бусад асуудлын хэсэг

Орон нутгийн төсөвт 560,651.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 374,341.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, биелэлт 166.8 хувь байна. Үүнд 12 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 249 хувиас 106.4 хувиар биелж, хог хаягдлын хураамж 66.4 хувиар, торгуулийн орлого 45.1 хувиар тасарсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 335,438.9 мянган төгрөгийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 8 ажлыг 247,214.6 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Сумын төсвийн орлого зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,076,505.00	1,573,318.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	658,074.20	1,059,125.80
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0	0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	285,015.50	262,162.70
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	133,415.20	252,029.40
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0	0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		937,790.20	1,033,788.20
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0	0
37100	Урт хугацаат хадгаламж		0	0
37200	Үнэт цаас		0	0
37300	Урт хугацаат зээл		0	0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	937,790.20	1,033,788.20
39100	Газар		0	0
39200	Биет хөрөнгө		873,518.40	970,870.10
39300	Биет бус хөрөнгө	13	64,271.80	62,918.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,014,295.20	2,607,106.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,501.60	2,359.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,501.60	2,359.80
41100	Богино хугацаат үнэт цаас		0	0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0	0
41300	Өглөг	17а, 17б	368.1	1,226.40
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,133.40	1,133.40
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0	0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0	0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,012,793.60	2,604,746.30
51	Засгийн газрын хувь оролцоо		2,012,793.60	2,604,746.30
51100	Засгийн газрын оруулсан капитал		392,590.90	392,590.90
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0	0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0	0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0	0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0	0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0	0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0	0
51200	Хуримтлагдсан үр дүн		1,520,060.60	2,112,013.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		100,142.20	100,142.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,014,295.20	2,607,106.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,073,109.30	4,875,837.00

11	ТАТВАРЫН ОРЛОГО		714,061.00	919,155.10
110	Орлогын албан татвар		382,887.20	728,164.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		382,887.20	728,164.90
113	Хөрөнгийн албан татвар		51,729.30	27,129.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		279,444.60	163,860.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	266,554.00	334,861.60
120	Нийтлэг татварын бус орлого		266,554.00	334,861.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,092,494.30	3,621,820.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,788,898.10	4,023,119.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,788,898.10	4,023,119.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,229,289.80	1,715,776.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		407,210.20	715,839.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		50,446.80	86,060.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		45,864.30	409,690.80
2104	Хангамж, бараа материалын зардал		52,189.70	47,737.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,850.80	37,701.30
2107	Томилолт, зочны зардал		17,426.00	20,022.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		386,172.20	157,448.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		253,129.70	241,276.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,559,608.30	2,307,343.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		284,211.20	852,718.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		155,141.20	260,765.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		129,070.00	591,952.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,872,367.50	4,617,501.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		714,061.00	919,155.10
110	Орлогын албан татвар		382,887.20	728,164.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		382,887.20	728,164.90
113	Хөрөнгийн албан татвар		51,729.30	27,129.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		279,444.60	163,860.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		4,990.60	6,592.00
1181	Газрын төлбөр		83,109.70	70,449.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		191,344.20	86,819.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		65,812.20	76,526.40
120	Нийтлэг татварын бус орлого		65,812.20	76,526.40

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,092,494.30	3,621,820.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,606,811.20	3,856,845.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,606,811.20	3,856,845.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,047,206.40	1,546,645.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		405,187.80	711,358.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		51,775.00	88,209.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		45,864.30	409,690.80
2104	Хангамж, бараа материалын зардал		39,903.40	44,882.80
2105	Нормативт зардал		339	305.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,634.50	41,161.10
2107	Томилолт, зочны зардал		17,426.00	20,022.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		422,483.10	162,403.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		51,593.20	68,611.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,559,604.80	2,310,200.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		265,556.30	760,656.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		228,088.20	359,454.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		228,088.20	359,454.50
2200	Дотоод эх үүсвэрээр		228,088.20	359,454.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-228,088.20	-359,454.50
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		0	-150
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		0	150
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		37,468.20	401,051.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		620,606.10	658,074.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		658,074.20	1,059,125.90

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,885,187.60	0	1,885,187.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,464.00	0	-1,464.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,883,723.60	0	1,883,723.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0

6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	129,070.00	0	129,070.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,012,793.60	0	2,012,793.60
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,012,793.60	0	2,012,793.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,012,793.60	0	2,012,793.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	591,952.60	0	591,952.60
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,604,746.30	0	2,604,746.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Нэгтгэл		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,341,775.80	1,774,269.25	567,506.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,898,773.60	1,526,904.61	371,868.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,856,192.00	1,497,854.69	358,337.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	811,993.90	696,783.56	115,210.35
210101	Үндсэн цалин	354,246.00	347,375.43	6,870.57
210102	Нэмэгдэл	274,053.60	242,442.01	31,611.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,880.00	4,200.00	19,680.00
210104	Урамшуулал	47,948.70	28,429.90	19,518.80
210105	Гэрээт ажлын хөлс	111,865.60	74,336.22	37,529.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,499.20	83,745.85	17,753.35
210201	Тэтгэврийн даатгал	69,019.50	58,550.92	10,468.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,120.00	6,901.97	1,218.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,059.90	3,442.36	617.54
210204	Ажилгүйдлийн даатгал	4,059.90	2,947.11	1,112.79
210205	Эрүүл мэндийн даатгал	16,239.90	11,903.49	4,336.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	452,401.70	408,524.24	43,877.46
210301	Гэрэл, цахилгаан	54,730.60	35,139.97	19,590.63
210302	Түлш, халаалт	393,531.10	370,464.52	23,066.58
210303	Цэвэр, бохир ус	4,140.00	2,919.75	1,220.25
210304	Байрны түрээс	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	47,327.30	35,811.39	11,515.91
210401	Бичиг хэрэг	7,203.70	4,865.20	2,338.50
210402	Тээвэр, шатахуун	30,000.20	25,687.21	4,312.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,712.00	2,327.08	3,384.92
210404	Ном, хэвлэл	-	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,845.60	1,500.90	344.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,565.80	1,431.00	1,134.80
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-	-
2105	Нормативт зардал	2,750.20	305.80	2,444.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-
210502	Хоол, хүнс	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,750.20	305.80	2,444.40

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,281.10	54,722.18	12,558.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,043.50	11,821.90	4,221.60
210602	Тавилга	13,676.00	5,585.90	8,090.10
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-
210604	Урсгал засвар	37,561.60	37,314.38	247.22
2107	Томилолт, зочны зардал	26,217.00	20,022.00	6,195.00
210701	Гадаад албан томилолт	-	-	-
210702	Дотоод албан томилолт	26,217.00	20,022.00	6,195.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	295,537.70	151,635.67	143,902.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,094.20	114,966.07	136,128.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	999.30	-	999.30
210803	Даатгалын үйлчилгээ	1,014.30	547.15	467.15
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536.40	248.54	287.86
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	99.00	146.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,786.70	988.50	798.20
210807	Газрын төлбөр	39,861.20	34,786.41	5,074.79
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,183.90	46,304.02	4,879.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,548.90	38,818.27	3,730.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,635.00	7,485.75	1,149.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,581.60	29,049.92	13,531.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,581.60	29,049.92	13,531.68
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,032.60	-	1,032.60
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,004.00	25,996.92	9,007.08
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,545.00	3,053.00	3,492.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	335,438.90	247,214.64	88,224.26
2200	Дотоод эх үүсвэрээр	335,438.90	247,214.64	88,224.26
220001	Барилга байгууламж	-	-	-
221001	Их засвар	-	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-	-
223001	Бусад хөрөнгө	335,438.90	247,214.64	88,224.26
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	107,563.30	150.00	107,413.30
230001	Эргэж төлөгдөх зээл	107,563.30	150.00	107,413.30
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	-	-	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,341,775.80	1,787,260.25	554,515.55
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,131,836.10	1,768,122.37	363,713.73
132001	Орон нутгийн төсвөөс	1,896,273.60	1,532,559.87	363,713.73
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	235,562.50	235,562.50	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	209,939.70	19,137.88	190,801.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.00	15,697.94	29,302.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500.00	3,439.94	939.94
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	162,439.70	-	162,439.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	162,439.68	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	175,430.68	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6	-
610001	Төсвийн байгууллага	6	6	-
610002	Төсвөөс гадуур байгууллага			-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-
620001	Удирдах ажилтан	8	8	-
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	-
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-
620004	Гэрээт ажилтан	4	4	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,267.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,387.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,414.97
2104	Хангамж, бараа материалын зардал	4,789.49
210401	Бичиг хэрэг	300.00
210402	Тээвэр, шатахуун	4,244.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	245.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	139.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,985.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,985.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,972.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	290.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	290.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,682.09
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,682.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,880.05
2200	Дотоод эх үүсвэрээр	97,880.05
223001	Бусад хөрөнгө	97,880.05
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,267.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,267.61
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,787.61
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,480.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Аварга тохижилт ОНӨҮГ-ын нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, ЕБС-ийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,553.9 мянган төгрөгийн 8 алдаа¹г санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан. Үүнд:

ЗДТГ: Ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээ нөхсөн, данснаас хасах шийдвэр гарсан 4,367.7 мянган төгрөгийн 4 хөрөнгийг тоног төхөөрөмжийн данснаас хасаагүй орхигдуулсан алдааг залруулав.

ИТХ: Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном, программ хангамжийн данснаас 10,701.7 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэргүйгээр данснаас хассаныг залруулав.

Аварга тохижилт ОНӨҮГ: Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийг буруу бүртгэсэн 4,337.0 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг залруулав.

3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 73,508.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлснээс 25,219.2 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,176.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 46,122.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Соёлын төв:

1. Жилийн эцэст бараа материалын дансны 37,445.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
2. Жилийн эцэст санхүү, сарын мэдээний, номын сангийн программын сунгалтын үнэд 960.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлэн зардлаар бүртгэснийг залруулав.
3. Аж ахуйн материалын данснаас анхан шатны баримтгүйгээр 24,259.2 мянган төгрөгийн материалыг зарлагдсаныг залруулав.

Ерөнхий боловсролын сургууль: Тайлант онд өндөр настны тэтгэврээ тогтоолгосон 1 багшид 1,771.5 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Хүүхдийн цэцэрлэг: Сахилгын шийтгэл оногдуулсан 1 ажилтанд сахилгын шийтгэл тооцсоноос хойш сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй байхад 405.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Эрүүл мэндийн төв:

1. Байгууллагын удирдлагын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, санхүүгийн зөрчилгүй ажиллах үүрэгтэй төсвийн шууд захирагчид тус сумын Засаг даргын захирамжаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон мөн тус төвийн эрхлэгчийн тушаалаар 2023 оны жилийн эцсийн балансын урамшуулал гэж 1,471.0 мянган төгрөгийг нягтлан бодогчид үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.
2. Байгууллагын эрхлэгчийн тушаалаар байгууллагуудын дунд зохион байгуулагдсан урлаг, спортын арга хэмжээнд идэвхтэй оролцсон 16 ажилтанд 3297.0 мянган төгрөг, мөн шилдэг ажилтан 2 хүнд 520.8 мянган төгрөг, өмч хамгаалах зөвлөлийн 4 гишүүдэд 997.6 мянган төгрөгийн шагналыг цалингийн сангаас улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан зардлын ангилал зөрчиж олгосон байна.
3. Тус байгууллагын эрхлэгчийн тушаалаар 2 ажилтанд 2023 оны ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 228,278.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

Албан шаардлага:

1. Ерөнхий боловсролын сургуулийн батлагдсан төсвөөс Хүүхдийн цэцэрлэгт 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.
2. Сумын төсвийн эх үүсвэрт урьд оны үлдэгдэл 141,323.3 мянган төгрөгийг бүрэн дайчилж батлаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	4,367.7	1	4,367.7			1	4,367.7				
ИТХ	1	10,701.7			1	10,701.7	1	10,701.7				
ХХС	1	147.5	1	147.5			1	147.5				
Аварга тохижилт	1	2,120.0	1	2,120.0			1	2,120.0				

Аварга тохижилт	1	6.0			1	6.0	1	6.0				
Аварга тохижилт	1	724.5	1	724.5			1	724.5				
Аварга тохижилт	1	190.1	1	190.1			1	190.1				
Аварга тохижилт	1	1,296.4			1	1,296.4	1	1,296.4				
ОНТБ-ын дүн	8	19,553.9	5	7,549.8	3	12,004.1	8	19,553.9				
Соёлын төв	1	960.0			1	960.0	1	960.0				
Соёлын төв	1	24,259.2			1	24,259.2	1	24,259.2				
УТБ-ын дүн	2	25,219.2	0	0	2	25,219.2	2	25,219.2				
Дүн	10	44,773.1	5	7,549.8	5	37,223.3	10	44,773.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Соёлын төв	1	37,445.7			1	37,445.7						
ЕБС	1	1,771.5	1	1,771.5								
Цэцэрлэг	1	405.0	1	405.0								
ЭМТ	1	8,666.8			1	8,666.8						
УТБ-ын дүн	4	48,289.0	2	2,176.5	2	46,112.5	0	0	0	0	0	0
ТТЗ	1	1,000.0			1	1,000.0						
ТТЗ	1	141,323.3			1	141,323.3						
ТТЗ-ийн дүн	2	142,323.3	0	0	2	142,323.3	0	0	0	0	0	0
Дүн	6	190,612.3	2	2,176.5	4	188,435.8	0	0	0	0	0	0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 165-ХЭА-2025/018/НА-СТА-ТТЗ
А2370447 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ерөнхий боловсролын сургуулийн батлагдсан төсвөөс Хүүхдийн цэцэрлэгт 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2. "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:" 41.2.2. "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.5. "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дэлгэрхаан сумын Засаг дарга Б.Энх-Амгалан, санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Х.Өнөрбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА

232505185



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 166-ХЭА-2025/018/НА-СТА-ТТЗ Чингис хот
А2370447

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын төсвийн эх үүсвэрт оны эхний үлдэгдлийн 141,323.3 мянган төгрөгийг бүрэн төлөвлөж, батлаагүй, үлдэгдлээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дэлгэрхаан сумын Засаг дарга Б.Энх-Амгалан, санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Х.Өнөрбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Н.ТУЯА

232505186

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112